

ХӨӨМИЙН ЭГШИГ ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ АСУУДАЛД

П. Даваапил *

Түлхүүр үг: Хөөмий /*qügete*/, Хөгжим /*rol mo*/, өгүүлэхүйн эрхтнүүд: Уушиг, мөгөөрсөн хоолой, төвөнх ба дууны хөвч, багалзуур, ам хамрын хөндий ба түүний эрхтнүүдийг хамруулж үзнэ. Хоолойн цохилго /*mgrin-sgyur*/, Эгшиг тэмдэглэгээ /*dbyang yig*, Нота¹/

Оршил

Ж.Бадраа, Б.Одсүрэн, Л.Эрдэнэчимэг, Л.Хэрлэн, Ж.Долгорсүрэн, Э.Сандагжав, А.Цэдэн-Иш Ш.Энхжаргал, тэргүүтэй судлаач, хөөмийчид судалгааны ном товхимол, илтгэл өгүүллүүддээ хөөмийн гарал үүсэл, ангилалын тухайд өөр өөрийн саналыг дэвшүүлсэн байна. 1950-иад оноос БНХАУ, ОХУ, Франц, Япон, Герман, Англи, тэргүүтэй гадаадын судлаачид хөөмийг сонирхон судлаж янз бүрийн дүгнэлт, тодорхойлолтыг гаргажээ. Энэ дунд хөөмийн аялгуут эгшиг тэмдэглэгээнд буулгах асуудал нэн сонирхолтой байна. Бид энэ удаа дорно дахины ард түмний ая эгшгийг тэмдэглэх арга дээр тулгуурлан хөөмийг эгшиг тэмдэглэгээнд оруулахад юуг анхаарах нь зүйтэй вэ? гэдэгт хариулт өгөхийг зорьлоо. Ингэхдээ *хоолойн цохилго /mgrin-sgyur/* хэмээх эгшиг тэмдэглэгээнд тулгуурлан тайлбарлана.

Хөөмийг судлахын тулд орчин үеийн шинжлэх ухааны салбарууд болох хөгжим судлал, хэл шинжлэл, физик, биологи, сэтгэл судлал зэрэг олон шинжлэх ухааны үр дүнг харгалзан үзэж тэдгээрийн уулзвар дээр авч үзэх хэрэгтэй болдог. Харин дорно дахины сэтгэлгээний хандлагаар хөгжмийн онолын суурь ухагдахуунууд нь хоорондоо нягт харилцан шүтэлцээтэй ойлголтууд юм. Ялангуяа хэл, сэтгэлгээний онцлогтойгоо салшгүй холбоотой байдаг учраас их, бага таван ухаан, ялангуяа урлахуй ухаан, дуун ухааны ойлголт, томъёоллоос улируулан судлах шаардлагатай. Урлах ухаан нь бие, хэл, сэтгэлийн урлалаас бүрддэг. Хэлний ур²-ын нэгэн өвөрмөц нь дууны эрдэм буюу

* МУИС, Утга зохиол, урлаг судлалын тэнхим

¹ Жанцанноров Н. Хөгжмийн онолын нэр томъёоны хураангуй тайлбар толь. УБ. 1996. т.61

² Хэлний урлахын эрхэм дээд нь тарни урих, ном номлох, тэмцэх, туурвих тэргүүтэн хэлийг сурах эзэмшихийн ид чадал, номыг зохион бүтээхээс эхлээд уран цэцэн хэлээр утга гүнзгий санааг гарган, номлох тэмцэлдэхийн идийг үзүүлэх нь хэлний урын эрхэм дээд нь гэнэ. Хэлний урлахын эгэл ерийн нь ая эгшгийн зүйл, дуулан эгшиглэхийн зургаан янз: хувилах, хугалах, өргөх, дарах, бүдүүн нарийн, энэ

хөгжмийн шастир болно. Энэтхэг, Түвэдээс улбаатай хөгжмийн онолын гол зохиолын нэг болох “Хөгжмийн шастир”³-т хөгжмийг дотор нь “хамт төрсөн /lhan jig skyes pa'i rol mo/ хийгээд бусад шалтгаанаас гарсан/rkyen gzhan las byung ba'i rol mo/”(Sa skya bka' 'bum dpe bsdur ma lass a pan kun dga' rgyal mtshan gyi gsung 'bum pod bzhi pa bzhugs so. 2007, т.1) гэж хуваана. “Хамт төрсөн гэдэг нь хэвлий, хоолой, тагнай, хэл, хамар, шүд, уруул [3.86.4] зэрэг эрхтний оролцоотой гарч буй дуу, бусад шалтгаан гэдэгт дэлдэх, цохих, үлээх зэргээр дуу чимээ гаргах зориулалттай шавар, хулс, чулуу тэргүүтнээр хийж, тусгайлан хөг оруулсан бийбаа тэргүүтэн... [3.86.4] хөгжмийн зэмсгийг тэмдэглэж буй нь Агваангунгаасодномын тайлбараас тодорхой байна.[Даваасүрэн Д., Даваапил П. 2013, т.17].

Энэ нь Энэтхэг, Хятад, Түвэдэд ая эгшгийг махбодийн онолтой холбон үздэгээр тайлбарлагдана. Тухайлбал: “А, Э, НГ эхлэн Ха, Га төрлөөрөө огторгуй махбод болно..., ...тэдгээрийг дуудахуй цагт хоолойн орноос төрөхийн тул болой гэжээ. Эдгээр авиа уруул, хэл, шүд зэрэг эрхтний шууд оролцоогүйгээр амны хөндий ихэд уужим байж дуудагдаж байна. И эхлэн Я, Ш төрлөөрөө хий махбод гээд юуны тул хий махбод гэвэл, үсэг тэдгээрийг дуудахуйд хэлний үзүүр шүдэн тагнайгаас гарах болой..., О, Ө эхлэн Ма, Ба, Па төрлөөрөө хийгээд Ва, Фа эдгээр үсгийг усан махбодот үсэг гээд уруул хумбихуйн орноос гардаг гэжээ. Хэлний үзүүр шүднээс бүтдэг Да, Та, На, Ла, Са эдгээр үсгүүдийг төрлөөр нь шороймахбодот гэжээ. Ра, Жа, Ча үсгүүдийг төрлөөр нь гал махбод гээд үсэг тэдгээрийг дуудахуйд орой хөдөлж гардаг” гэжээ. (Пагва Т. 1959. т.15-16) “Бас авиаг үгүүлэхийн эрхтний оролцоог ажиглан тайлбарласны зэрэгцээгээр, ямар нэгэн авиаг хэлэхэд хүний биеийн дотоод эрхтэн: уушиг, зүрх, элэг, дэлүү, бөөр зэргийн аль нь илүү оролцох байдлыг тэр үеийн анагаах ухааны амжилтанд дулдуйдан тайлбарласан байдаг. ..., авиаг махбодоор, хятадын ёсоор ялгахдаа А, Э, НГ эхлэн Ха, Га төрлөөрөө модон махбод бөгөөд юуны тул хэмээвээс элэгний хийгээс төрсөн тул болай. И эхлэн Я, Ша төрлөөрөө гал махбод бөгөөд, юуны тул хэмээвээс зүрхний хийгээс төрсний тул болай. Ра, Жа, Ча төрлөөрөө төмөр махбод бөгөөд юуны тул хэмээвээс, уушигны хийгээс төрсний тул болай. О эхлэн Ма, Ба, Па төрлөөрөө хийгээд Ва, Вфа усны махбод бөгөөд юуны тул хэмээвээс, бөөрний хийгээс төрсний тул болай” [Пагва Т. 1959. т.16] гэснээс үзвэл дорно дахины улс орнуудын хэл, дуу авиа гээд бүх салбар ухаанууд хоорондоо учир шалтгааны ухаанаар холбогдсон байна. Манай судлаачид ч хөөмийг судлахдаа мөн адил монгол хэлний авиа эгшигтэй уялдуулан судлаж хөөмийг ангилахдаа дуу бүтэх оронтой холбон үзэж ирсэн нь санаандгүй хэрэг биш. “Хөгжмийн шастир”-т хамт төрсөн ая эгшиг нь татах /'dren pal/, нугалах /bkug pal/, урвуулах /bsgyur bal/, өргөх /ltengs pal/ гэх дөрвөн янз байх бөгөөд тэдгээр нь мөн дотроо тус тусын ялгаатай болохыг өгүүлсэн байна.

Тэгвэл манай судлаачид хөөмийг хэрхэн томъёолсныг авч үзье. Ж.Бадраа “Монгол ардын хөгжим” номондоо Монгол ардын хөгжмийн өгүүлэхүйн эрхтэнтэй шүтэлцэх урлагийг дотор нь “аялан исгэрэх урлаг, амаар таших дэлдэх урлаг, хөөмэйлэх урлаг, цуурдах урлаг, аман хуурын урлаг...”[Бадраа Ж. 1998, т.41] хэмээн хуваасан байна. Өгүүлэхүйн эрхтэнтэй шүтэлцэх урлаг гэж нэрлэснээ тайлбарлахдаа “...Хөгжим үүсгэх гэж монголчуудын хэлдэг хөгжмийн эгшигийг дуурьсгах арга зүйн хувьд хүний

зургаагаа цааш нь мөн арван янз маягаар хувилгаж жаран эгшигт болгож, яруу тунгалаг, сүр жавхлант, сүрхий дорвилог ая эгшгийг бүтээдэг байна.

³ Rol mo'i bstan bcos zhes bya ba bzhugs so. Сажа бандида Гунгаажалцан (1182-1251) зохиосон. Эгшгийн найруулга, Үгийн найруулга, Эгшиг хийгээд үгийн найруулга гэсэн гурван бүлэгтэй.

өгүүлэхийн эрхтэн хөгжмийн зэмсгийн үүрэг гүйцэтгэх юм уу, эсхүүл өгүүлэхийн эрхтэн хөгжмийн зэмсэгтэй хавсран нэгдэж, тэрхүү зэмсгийн ямар нэгэн эд анги болдогт байгаа юм” [Бадраа Ж. 1998, т.41] гэсэн үндэслэгээг дэвшүүлжээ. Энд хүний өгүүлэхүйн эрхтэн хөгжмийн зэмсгийн үүрэг гүйцэтгэх эсвэл хөгжмийн зэмсгийн ямар нэгэн хавсрагч эд анги болох талыг нь чухалчлан өгүүлсэн байна. Үүнээс улбаалан “Тэгэхээр хөөмэй гэдэг нь ерөнхий утга нь “хөндий” юмыг нэрлэж байгаа юм. Өөрөөр хэлбэл хөөмэйлэх урлаг нь хүн хөгжим буюу өгүүлэхүйн эрхтэнээ “хөгжмийн зэмсэг” болгож байгааг хэлж байна” [Одсүрэн Б. 2009. т.9], “Соёлт хүмүүн бүтээлч, оюунлиг мөн чанарынхаа үрээр хөг аялгуу бүтээн ертөнцтэй харилцахдаа өөрийн бие махбодийн дээд боломжийг ашиглаж өгүүлэхүйн эрхтнүүдийг “хөгжмийн зэмсэг”-ийн үүрэг гүйцэтгэх хэмжээнд хөглөн удирдаж улмаар дуурьсал бий болгож буй үйлийг хөөмэйлэх гэж нэрлэдэг” [Долгорсүрэн Ж. 2013. т.57], “Орчин цагийн ойлголтоор бол “Хүн хөгжим” гэж ойлгож болмоор байгаа юм” [Сандагжав Э. 2010. т.30] гэх зэргээр тайлбарлаж байна.

Чухамдаа хүний өгүүлэхүйн эрхтний угаас хамт төрсөн авиа эгшиг болон хэлний авиа эгшгийн гүйцэтгэх үүргийг орхигдуулалгүй харин ч хүний дуу бүтэх орон тэдгээртэй холбоо бүхий хэл хоолойн урлалуудтай уялдуулан судлах нь чухал юм. Ингэж үзвэл татах/*dren pa*/, дуулах/*dayulaqu, glu len pa*⁴/ зэрэг хэл хоолойн урлалууд нь хамт төрсөн хөгжимд суурилдаг болох нь илэрхий байна. Гэтэл өгүүлэхүйн эрхтэнтэй шүтэлцэх урлагийн дотор буй хөөмий, исгэрээ, таших дэлдэх гэх урлалууд нь өгүүлэхүйн эрхтний оролцоотой шууд гарах ая эгшгээс ялгаатай урлал болох юм. Учир нь хөөмий, исгэрээ, таших дэлдэх гэх урлалууд нь хүний өгүүлэхүйн эрхтний дуу гаргах боломжид тулгуурласан тусгаар тусгаар урлалууд бөгөөд хамт төрсөн хөгжим хэмээхдээ багтах ойлголт юм. Харин цуурдах урлаг, аман хуурын урлаг зэрэг нь төмөр, мод зэрэг материалыг ашиглахын зэрэгцээ хүний өгүүлэхүйн эрхтнээс өөр бусад эрхтнүүдийн цохих, дэлдэх тэргүүтэн үйл хамсарч байгаа тул бусад шалгаанаас гарсан хөгжимд хамаарах ойлголт гэж бид үзэж байна.

Ингэхлээр бидний өгүүлэн буй өгүүлэхүйн эрхтэнтэй шүтэлцэх урлаг гэх ангилал дотор буй ая эгшгийн зүйлүүд нь хамт төрсөн болон бусад шалтгаанаас гарсан хөгжмийн аль алинтай нь хамаатах ойлголт болох нь харагдаж байна. Тэр дундаа хөөмий нь хамт төрсөн хөгжмийн доторх хэл хоолойн урлалын нэгэн өвөрмөц урлал болно. Өөрөөр хэлбэл дээр өгүүлсэн хамт төрсөн хөгжимд буй *tamax* /*dren pa*/, *нугалах* /*bkug pa*/, *урвуулах* /*bsgyur ba*/, *өргөх* /*ltengs pa*/ гэх дөрвөн зүйл аялгуунаас бүтэх орон хийгээд аргын хувьд ялгаатай урлал байна. Харин хөөмийд эдгээр аялгуутай төсөөтэй урлал, чимэглэлүүд байна. Энэ удаа бид хоолойн цохилго хэмээх урлалыг сонгон авч хөөмийн урлалд хэрхэн тайлбарлагдах хийгээд хоолойн цохилгыг сурвалжид тэмдэглэсэн баримтаас улируулан хөөмийг эгшиг тэмдэглэгээнд буулгахад юуг анхаарах хэрэгтэйг өгүүлэе.

Аялгууг хөөмийлэх нь өгүүлэхүйн эрхтнүүдийн тухайн аялгуунд өгөгдсөн хөгжмийн эгшгийг дуугаргах агшин бүрийн байрлал, тэдгээрийн хоорондын шилжилтүүд гэж үзэж болно. Энэ үед хөөмийн аялгууг өгүүлэхүйн эрхтнүүдийн маш нарийн нийлмэл үйл ажиллагаа хөтлөн удирдана. Ингэхдээ аялгууг жолоодох гол эрхтэн нь хэл байдаг тул аялгуунд чимэглэл хийх хамгийн өргөн боломж түүнд

⁴ Мэргэд гарахын орон-д Ролбийдорж. *Dag yig mkhas pa'i 'byung gnas*. Өвөрмонголын үндэсний хэвлэлийн хороо. 2002. т.1150

хадгалагдаж байдаг. Хөөмийн урлалд хэлээ ҮЕЛЗҮҮЛЭХ нь хөөмийн нэгэн зүйл чимэглэл болох бөгөөд татах, дуулах тэргүүтэн хэл хоолойн урлалын ЦОХИЛГО хэмээх чимэглэлтэй төсөөтэй юм. Татах, дуулах урлалд цохилгыг хэрхэн тайлбарласныг авч үзвэл: Үүний хэл болон хоолойн урлалд “цохих /‘gyur/, нугалах /khugs/, өргөх /‘deg/, зогсох /‘jog/, бүдүүн /spong/, нарийн /phra ba/ зургаан төрлийн төрх байдалд суралцан үйлдэх хэрэгтэй” [Khu ril chen mo’i dbyangs khungs zhes so. т.3a] гэжээ. Энд “хоолойн урлалд урвуулах” гэсэн нь бидний хоолойн цохилго гэж нэрлэж буй эгшиг тэмдэглэгээг зааж байна.



хоолойн цохилго /mgrinsgyur/

“УРВУУЛАХ-ад:

Хоолойгоор /тү: mgrin, энэ “урвуулах” гэж буй нь түвэд үгний оноосон орчуулга юм. Энэ үесийн утга нь хэвлий, уушги зэргээс гарч буй хийг хоолойгоороо цохих буюу хоолойгоо чичиргэн хөдөлгөхийн нэр болов уу. Д.Д/ Монголчуудын татах, дуулах урлалд хоолойгоор урвуулах нь түгээмэл байна. Энэ нь ямар учиртай болохыг хэл шинжлэлийн ухааны доктор Г.Гантогтох тайлбарлахдаа “Дуу авиаг хоолойн хугалган, амны аялган гэж хоёр хуваадаг. Хөөмэйн хэсэгт гаргаж байгаа авианы ая, хэм хэмнэлийг хугалган, амны хөндийн дуун авиаг аялган гэж нэрлэдэг. Монгол хэл нь ерөөсөө хөөмэйн хөндийд дуу авиа цуглуулдаг хэл юм, тийм учраас амаа бага хөдөлгөж ярьдаг. Гадаад (Европ, Орос) хэл бол аялган авиаг гаргаж гадагш нь хэлж, уруул амаа жомболзуулан хөдөлгөж ярьдаг хэл. Тиймээс хөөмэйн урлаг нь бөө мөргөлтнүүд Монгол, Киргиз, Хакас, Алтайн иргэдэд байдаг үзэгдэл бөгөөд тэр нь тухайн бөө мөргөлд хөөмэйгээр хугалган гаргаж тотем, сүг, онгодоо дуудах зан үйлтэй холбоотой хөгжсөөд хожим нь урлаг болсон байх” [Хэрлэн Л. 2010. т.12-13].

Хэлээр /тү: lce, энэ нь мөн хэвлий, уушгинаас гарч буй хийг хэлний оролцоотойгоор цохих, чичиргэх гэсэн утга бололтой. Бидэнд буй бусад сурвалжид хоолойгоороо урвуулах гэх утга бүхий mgrin-sgyur гэх нэр байхаас хэлээрээ цохих гэсэн утгатай нэр байхгүй байна. Тиймээс энэ нь түгээмэл арга барил биш бололтой байна. Д.Д/ татах, дуулах урлалд түгээмэл биш ч хөөмийлэх урлалд хамгийн гол урлал болно. Учир нь хөөмийн урвуулах хэмээх нь хэл хоолойн урлалын аль урлал болохоос хамаарч ахуй, хэл дууны онцлог дээрээ тулгуурлан их, багын ялгал гарч байж болно. Хэл дууны онцлогоос хамаарна гэдэг нь Монголчууд хоолойн цохилгыг түлхүү хэрэглэж байхад Түвэдүүд хамрын цохилгыг гол төлөв хэрэглэдэг бөгөөд Түвэд, Монгол нь дотроо газар орон, хэл аялгын ялгаагаар бас өөр өөр байна.

Хамраар /тү: sna, мөн хэвлий, уушгинаас гарч буй хийг хамрын оролцоотойгоор цохих, чичиргэх гэсэн утгатай, түгээмэл бус арга барил бололтой. Д.Д/ гэх гурван зүйл, үргэлжлэх хугацааны хувьд тус бүр УРТ, БОГИНО хоёр янз, ингээд нийт 6 зүйл урвуулах арга барил байдаг ажээ” (Даваасүрэн Д., Даваапил П. 2013, т.22).

“Динжүр” хэмээхийг Н.Жанцанноров “Уртын дууны уламжлалт зарим нэр томъёоны гаргалгаа” хэмээх бүтээлдээ Дэнжир-Фрошлаг⁵ (хугалаа)-тай төстэй хоолойн цохилго чимэглэгээг хэлж байна. Дэнжир нь төвд гаралтай үг байж болох. Дорждагва гуайн ярианд “Лам нарын янд дэнжир нэртэй байдгийм гэсэн бий. Эрлэг номун хааныг

⁵ 1. Богино \короткий\ хугалаа; үндсэн эгшгийн өмнө дуурьсах нэг буюу хэд хэдэн маш богино эгшиг

2. Урт \долгий\ хугалаа; үндсэн эгшгийн уртын хэмжээнд багтааж дуулж хөгжимдөх түүний өмнө орсон нэг эгшиг.

одоо ингэж зална шүү дээ гэсэн бий. Сонсоход дахин давтан авч байгаа эгшиг болгоноо дээрээс их хоёрц, бага гуравц, дөрөвц, тавцын дээр байгаа эгшигнээс доош нь татаж дуулах аргыг хэлж байна. Энэ дэнжирдэх нь холоос татах тусам илүү сайхан сонсголонтой байдаг. Иймд уртын дуу дуулж сурахад дэнжирдэх гэсэн нэг бие даасан хоолойн хөдөлгөөний арга байгааг онцлон үзүүштэй. Энэ дэнжир нь дахин дахин авч байгаа эгшгийг тов тодорхой байдлаас нь гаргаж хөг тогтворгүй байдалд оруулж орон зайг нэмэгдүүлж байгаа сонирхолтой арга гэж үзвэл зохилтой. Уртын дуучин болох хүн энэ дэнжирдэх аргыг аль болох сайн хийж сурах тусам дуулах ур чадал нь дээшлэх нь лавтай” [Жанцанноров Н. 2005. т.33-34] гэсэн байна.

Ш.Чимэдцэеэ “Дарьганга ардын дууны аялгууны онцлог” [Монголын соёл, урлаг судлал XIII. 2011. т.126-131] илтгэлдээ уртын дууны аялгууг өрнө дэхнийноот тэмдэглэгээнд буулгахад хүндрэлтэй байдаг тул өөрийн олон жилийн туршлага дээрээ үндэслэж “Сэтгэлгээний эгшиглээст тэмдэглэгээ” хэмээх дүрс, зурлагыг зохион тэмдэглэсэн байна. Энд гурван зүйлийн **цохилго** /Бөнжигнөх хөдөлгөөн, төвөнхи

хоолой, төвөнхи хавсарсан , төвөнхи хоолой хавсарсан ,
дан төвөнхи , хоёр зүйлийн **цохилт** /цээжний , хамрын
☺ / нийт 5 зүйлийн тэмдэглэгээг дүрсэлжээ. Эдгээр цохилт, цохилгыг тэмдэглэсэн

тэмдэглэгээ нь дээр өгүүлсэн хоолойн цохилго  -той адил байгаа нь ихээхэн сонирхолтой байна. Өөрөөр хэлбэл тэртээ өндөр гэгээний үе дэх хоолойн цохилгыг тэмдэглэх гэсэн оролдлого эдүгээ цагийн уртын дуучны төвөнхи, хоолойн цохилгыг тэмдэглэсэн зурлагатай адил байгаа нь угтаа энэхүү чимэглэлүүд нь холбоотой болохыг илтгэж байна. Мөн дүрсэлж буй сэтгэлгээний хувьд ч нэгэн сэжмээр холбогдож байна. Тиймээс бид дээрх баримтуудаас үлгэрлэн хөөмийлэх үед хэлээ үелзүүлэх чимэглэлийг дээрхтэй төстэй байдлаар тэмдэглэж болно гэж үзэж байна. Эндээс бид дараах саналыг дэвшүүлж байна. Хөөмийд хэлээ үелзүүлэх чимэглэлийг хэл /хэлний зургаар тодотгож

болно/ гэсэн тодотголтой  гэж тэмдэглэх боломжтой. Ингэж дүрс тэмдэглэгээгээр тэмдэглэхийн давуу талыг товч өгүүлбэл: Өрнийн таван шугамт нот тэмдэглэгээнд тэмдэглэх боломжгүй уралалыг тэмдэглэх боломжтой. Өөрөөр хэлбэл хоолойн цохилго, хэлээ үелзүүлэх зэргийг тэмдэглэх боломжтой. Мөн хувь дуучны ур чадварыг илтгэх өвөрмөц чимэглэлүүдийг тэмдэглэн үлдээж хойч үеийн судлаачдад харьцуулан судлах боломжийг бүрдүүлнэ.

Бидний жишээ болгон авсан хоолойн цохилго гэх эгшиг тэмдэглэгээг хөөмийд хэрэглэхдээ хэлний үелзүүлэн хийх чимэглэлийг тэмдэглэхэд ашиглаж болно хэмээн үзэж байна. Өөрөөр хэлбэр татах, дуулах, хөөмийлэх уралалын алинд нь хэрэглэж буйг тодотгон, хоолойн цохилго, хэлний цохилго, хамрын цохилго зэргийн алин болохыг ялган хэрэглэвэл ач тустай юм. Улмаар эндээс жишээлэн дуу бүтэх орон [хөөмийн ангилалтай холбон авч үзэх], түүний үйл ажилгааг энэ мэтээр тэмдэглэх нь газар орон, хэл авианы ялгамж, нугалаа чимэглэлийг харьцуулан судлахад чухал хэмээн үзэж байна. Цаашид дандилдах /ташилдах/, уруулаар хөг солих, хэлээр үелзүүлэх зэргийг эгшиг тэмдэглэгээнд хэрхэн буулгах тухай асуудлыг судлах хэрэгтэй. Мөн тухайн

хөөмийч хэрхэн тайлбарлаж буй болон сонсоочид хэрхэн хүртэгдэж байгаа зэргээс нь хамааруулан тэмдэглэгээнд буулгах нь зүйтэй гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Хөөмийг ангилахдаа хамт төрсөн хөгжимтэй холбож үзэх нь зүйтэй. Ингэхдээ хүний биеийн дуу бүтэх орон хийгээд хэл яриа, газар орон, сэтгэлгээний тулгуур зарчмууд дээр суурилах хэрэгтэй. Үүнээс улбаалан нэр томъёог хэрэглэх, эгшиг тэмдэглэгээнд буулгах асуудлыг цогцоор нь авч үзэх шаардлагатай байна.

Хэлээр үелзүүлэх нь хөөмийн урлалын хамгийн гол чимэглэлийн нэг бөгөөд хамт төрсөн хөгжмийн зүйлд буй татах, дуулах тэргүүтэн хэл хоолойн урлалын хоолойн цохилго, хамрын цохилго, хэлний цохилго хэмээх нэрлэгээ, тэмдэглэгээтэй төсөөтэй байна.

Цаашид хөөмий, түүний чимэглэлүүдийг хэл хоолойн урлалын бусад урлалуудтай холбогдуулан судлах, уламжлалт болон орчин үеийн хөгжмийн эгшиг тэмдэглэгээний арга, туршлагаас суралцан соёлын биет бус өв тээгчдийн тус тусын арга барилыг эгшиг тэмдэглэгээнд буулгах хойч үедээ өвлүүлэх, сургалтад ашиглах шаардлагатай байна.

НОМЗҮЙ

1. Бадраа Ж. (1998), *Монгол ардын хөгжим*. УБ.,
2. Даваасүрэн Д., Даваапил П. (2013), “*Хөгжмийн шастир*”-ын нэгдүгээр бүлэгт хийсэн зарим ажиглалт. Ян-ег нь монголын уламжлалт хөгжмийн эгшиг тэмдэглээ мөн болох нь. /эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/ УБ.,
3. Долгурсүрэн Ж. (2013), *Нүүдэлчний болон суурьшмал соёлын хосолмол орон зай дахь монгол хөөмэйн хөгжил*. Nomadic Culture and New Spiritual Culture. /Tree of Culture 2013/ Daum society. Korea.
4. Жанцанноров Н. (2005), *Уртын дууны уламжлалт зарим нэр томъёоны гаргалгаа*. УБ.,
5. Жанцанноров Н. (1996), *Хөгжмийн онолын нэр томъёоны хураангуй тайлбар толь*. УБ.,
6. Одсүрэн Б. (2009), *Хөөмэйлэх арга барил*. /Урлаг судлалын ухааны магистрын зэрэг горилсон бүтээл/ УБ.,
7. Пагва Т. (1959), *Хэл шинжлэлийн удиртгал*. УБ.,
8. Ролбийдорж (2002), *Мэргэд гарахын орон-д Dag yig mkhas pa'i 'byung gnas*. Өвөрмонголын үндэсний хэвлэлийн хороо.
9. Сандагжав Э. (2010), *Монгол хөөмэй*. УБ.,
10. Хэрлэн Л. (2010), *Монгол хөөмэйн утга холбогдол*. УБ.,
11. Цэвэл Я. (1966), *Монгол хэлний товч тайлбар толь*. УБ.,
12. Чимэдцэеэ Ш. (2011), *Дарьганга ардын дууны аялгууны онцлог*. Монголын соёл, урлаг судлал XIII. УБ.,
13. Энхжаргал Ш. (2006), *Монгол хөөмэйн төрөл зүйлийн онцлог*. /Урлаг судлалын ухааны магистрын зэрэг горилсон бүтээл/ УБ.,

14. Ngag dbang kun dga' bsod nams. *Rig pa'i gnas lnga nas bzo rig pa'i bye brag rol mo'i bstan bcos kyi rnam par bshad pa 'jam dbyangs bla ma dges pa'i snyan pa'i sgra dbyangs blo gsal yid 'phrog phrin las yongs khyab ces bya ba bzhugs so.* Төвөд эх. Дэргэ бар.
15. Sa skya bka' 'bum dpe bsdur ma lass a pan kun dga' rgyal mtshan gyi gsung 'bum pod bzhi pa bzhugs so. (2007), Бээжин.
16. "Khu ril chen mo'i dbyangs khungs zhes so" буюу "Их хүрээний ая эгшгийн уг гарал" За тал. Төвөд гар бичмэл.

АННОТАЦИЯ

Ученые и исследователи выдвигали свои предложения о происхождении и способах горлового пения. При этом они основывались на понятиях западной музыкальной терминологии. Но при этом редко считались с структурой теории восточной музыки. Поэтому мы старались раскрыть связь между горловым пением и теорией мышления восточной музыки, и также хотелось бы объяснить возможности нотирования.